



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/13/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Архангай аймаг

2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn

Аудитор П.Энхжаргал

Утас: 99743112

Цахим хаяг: enkhjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Албан шаардлага .....	14
4.2 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1.Аудитын санал дүгнэлт



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс:976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.14 № 14  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖИМТ  
ДРАМЫН ТЕАТРЫН ДАРГА  
Ж.НЯМСҮРЭН ТАНАА

#### Аудитын санал дүгнэлт

##### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас тухайн байгууллагын төсөв захирагч нь өөрийн хамаарал бүхий этгээдтэй гэрээ байгуулж 8750000 төгрөгийг жүжгийн хөгжмийн найруулга, мөн фонаграмм хийлгэсний хөлсөнд олгосон нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.4, 7.2.5, 8.1, 8.2, Төсвийн тухай хуулийн 6.4.1 дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

##### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>221,704,756.50</b>	<b>229,252,379.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>433,278.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	433,278.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>221,704,756.50</b>	<b>228,819,101.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>221,704,756.50</b>	<b>228,819,101.00</b>
35410	Бичиг хэргийн материал	95,500.00	224,000.00
35420	Аж ахуйн материал	218,468,756.50	226,066,941.00
35430	Сэлбэг хэрэгсэл	160,000.00	160,000.00
35440	Түлш, шатах тослох материал	580,000.00	182,660.00
35450	Барилгын засварын материал	2,400,500.00	2,185,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>440,511,489.05</b>	<b>412,192,714.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>440,511,489.05</b>	<b>412,192,714.31</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>388,091,489.05</b>	<b>360,072,714.31</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	199,406,376.49	194,172,788.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33,361,795.20	-44,809,104.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	129,667,777.78	129,667,777.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-98,867,777.70	-104,467,777.84
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	278,303,250.42	299,630,596.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	-184,490,577.37	-201,382,317.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	127,843,130.50	127,310,530.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,228,045.58	-40,852,528.44
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,899,000.00	4,899,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,079,850.29	-4,096,250.33
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>52,420,000.00</b>	<b>52,120,000.00</b>
39301	Програм хангамж	1,200,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	51,520,000.00	51,520,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>662,216,245.55</b>	<b>641,445,093.31</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>433,278.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>433,278.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>433,278.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	433,278.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>662,216,245.55</b>	<b>641,011,815.31</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>662,216,245.55</b>	<b>641,011,815.31</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	543,983,879.45	543,983,879.45
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-122,531,552.47</b>	<b>-143,306,437.59</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-277,196,857.18	-122,102,007.35
51220	Тайлант үеийн үр дүн	154,665,304.71	-21,204,430.24
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	240,763,918.57	240,334,373.45
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>662,216,245.55</b>	<b>641,445,093.31</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>872,893,350.00</b>	<b>732,277,920.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>198,398,650.00</b>	<b>34,219,520.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>198,398,650.00</b>	<b>34,219,520.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>12,653,150.00</b>	<b>0.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,653,150.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	183,043,500.00	28,868,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,702,000.00	5,351,520.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>674,494,700.00</b>	<b>698,058,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,500,000.00</b>	<b>15,550,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,500,000.00	11,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	4,050,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>665,994,700.00</b>	<b>682,508,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	665,994,700.00	682,508,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>718,228,045.29</b>	<b>753,457,600.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>718,228,045.29</b>	<b>753,457,600.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>661,498,523.80</b>	<b>692,825,257.77</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>481,583,299.25</b>	<b>465,395,400.51</b>
210101	Үндсэн цалин	384,958,352.25	382,321,141.34
210102	Нэмэгдэл	78,772,968.00	67,695,127.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,851,979.00	15,379,131.52
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,172,979.48</b>	<b>61,326,219.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,805,909.48	42,718,149.73
210202	Тэтгэмжийн даатгал	4,933,616.00	4,754,754.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,908,577.00	3,733,243.57
210204	Ажилгүйдлийн даатгал	954,472.00	911,188.93
210205	Эрүүл мэндийн даатгал	9,570,405.00	9,208,883.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,640,564.28</b>	<b>29,243,334.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	426,964.28	275,234.56
210302	Түлш, халаалт	34,113,600.00	28,868,100.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,709,633.50</b>	<b>27,659,173.18</b>
210401	Бичиг хэрэг	722,500.00	921,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,785,000.00	1,897,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	697,433.50	782,111.68
210404	Ном, хэвлэл	257,600.00	120,984.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,247,100.00	2,136,501.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	21,800,736.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,845,600.00</b>	<b>100,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,845,600.00	100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,194,300.00</b>	<b>10,193,000.00</b>
210604	Урсгал засвар	4,194,300.00	10,193,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>435,600.00</b>	<b>1,278,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	435,600.00	1,278,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,724,830.00</b>	<b>40,467,305.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,448,830.00	39,017,305.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	400,000.00
210807	Газрын төлбөр	450,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,191,717.29</b>	<b>57,162,024.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	821,490.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,370,227.29	57,162,024.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,729,521.49</b>	<b>60,632,342.42</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,940,200.00</b>	<b>39,166,680.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	4,050,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,940,200.00	21,329,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	13,786,980.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>34,789,321.49</b>	<b>21,465,662.42</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,789,321.49	21,465,662.42
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>154,665,304.71</b>	<b>-21,179,680.19</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>24,750.05</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	24,750.05
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>154,665,304.71</b>	<b>-21,204,430.24</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	543,983,879.45	240,763,918.57	-277,196,857.18	507,550,940.84
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	543,983,879.45	240,763,918.57	-277,196,857.18	507,550,940.84
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	154,665,304.71	154,665,304.71
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	543,983,879.45	240,763,918.57	-122,531,552.47	662,216,245.55
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	543,983,879.45	240,763,918.57	-122,531,552.47	662,216,245.55
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	429,545.12	429,545.12
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	543,983,879.45	240,763,918.57	-122,102,007.35	662,645,790.67
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-429,545.12	0.00	-429,545.12
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-21,204,430.24	-21,204,430.24
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	543,983,879.45	240,334,373.45	-143,306,437.59	641,011,815.31

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>687,147,850.00</b>	<b>698,058,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,653,150.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>12,653,150.00</b>	<b>0.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>12,653,150.00</b>	<b>0.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,653,150.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>674,494,700.00</b>	<b>698,058,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,500,000.00</b>	<b>15,550,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,500,000.00	11,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	4,050,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>665,994,700.00</b>	<b>682,508,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	665,994,700.00	682,508,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>684,555,850.00</b>	<b>698,058,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>684,555,850.00</b>	<b>698,058,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>627,826,328.51</b>	<b>637,426,057.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>481,583,299.25</b>	<b>465,395,400.51</b>
210101	Үндсэн цалин	384,958,352.25	382,321,141.34
210102	Нэмэгдэл	78,772,968.00	67,695,127.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,851,979.00	15,379,131.52
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,172,979.48</b>	<b>61,326,219.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,805,909.48	42,718,149.73
210202	Тэтгэмжийн даатгал	4,933,616.00	4,754,754.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,908,577.00	3,733,243.57
210204	Ажилгүйдлийн даатгал	954,472.00	911,188.93
210205	Эрүүл мэндийн даатгал	9,570,405.00	9,208,883.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,390,564.28</b>	<b>29,243,334.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	426,964.28	275,234.56
210302	Түлш, халаалт	29,863,600.00	28,868,100.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,444,901.50</b>	<b>5,532,612.68</b>
210401	Бичиг хэрэг	750,000.00	1,050,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,300,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	697,433.50	782,111.68
210404	Ном, хэвлэл	499,568.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,197,900.00	2,200,501.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,995,600.00</b>	<b>1,663,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,995,600.00	1,663,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,194,300.00</b>	<b>9,978,000.00</b>
210604	Урсгал засвар	4,194,300.00	9,978,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>435,600.00</b>	<b>1,278,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	435,600.00	1,278,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,609,084.00</b>	<b>63,008,690.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,333,084.00	61,558,690.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	400,000.00
210807	Газрын төлбөр	450,000.00	450,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,729,521.49</b>	<b>60,632,342.42</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,940,200.00</b>	<b>39,166,680.00</b>

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	4,050,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,940,200.00	21,329,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	13,786,980.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>34,789,321.49</b>	<b>21,465,662.42</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,789,321.49	21,465,662.42
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,592,000.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,592,000.00</b>	<b>0.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,592,000.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,592,000.00</b>	<b>0.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,592,000.00	0.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-2,592,000.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>682,508,400.00</b>	<b>661,042,737.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>682,508,400.00</b>	<b>661,042,737.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>647,391,700.00</b>	<b>625,926,057.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>482,519,200.00</b>	<b>465,395,400.51</b>
210101	Үндсэн цалин	399,321,900.00	382,321,141.34
210102	Нэмэгдэл	67,817,400.00	67,695,127.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,379,900.00	15,379,131.52
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>65,140,100.00</b>	<b>61,326,219.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,839,300.00	42,718,149.73
210202	Тэтгэмжийн даатгал	4,825,200.00	4,754,754.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,860,200.00	3,733,243.57
210204	Ажилгүйдлийн даатгал	965,000.00	911,188.93
210205	Эрүүл мэндийн даатгал	9,650,400.00	9,208,883.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,637,100.00</b>	<b>29,243,334.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	669,000.00	275,234.56
210302	Түлш, халаалт	28,868,100.00	28,868,100.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,626,000.00</b>	<b>5,532,612.68</b>
210401	Бичиг хэрэг	1,050,000.00	1,050,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	875,000.00	782,111.68
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,201,000.00	2,200,501.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,666,700.00</b>	<b>1,663,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,666,700.00	1,663,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,978,000.00</b>	<b>9,978,000.00</b>
210604	Урсгал засвар	9,978,000.00	9,978,000.00
<b>2107</b>	<b>Томиллот, зочны зардал</b>	<b>1,310,800.00</b>	<b>1,278,800.00</b>

**Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	1,310,800.00	1,278,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>51,513,800.00</b>	<b>51,508,690.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,063,800.00	50,058,690.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210807	Газрын төлбөр	450,000.00	450,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,116,700.00</b>	<b>35,116,680.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,116,700.00</b>	<b>35,116,680.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,329,700.00	21,329,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,787,000.00	13,786,980.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>682,508,400.00</b>	<b>661,042,737.58</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>682,508,400.00</b>	<b>661,042,737.58</b>
320001	Орон нутгийн төсвөөс	682,508,400.00	661,042,737.58
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>50</b>	<b>48</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	42	42
620003	Үйлчлэх ажилтан	7	5

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,550,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,550,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,050,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,050,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,050,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,550,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,050,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөгжимт драмын театр нь урлаг, соёл, оюуны эрэлт хэрэгцээг чанартай уран бүтээл, ажил үйлчилгээгээр хангаж, ардын уламжлалт урлагийн орчин үеийн болон дэлхийн сонгодог урлагтай хослуулан хөгжүүлж, соёлын үйлчилгээ хүргэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Хүний эрхийг дээдлэн тэдний соёл, оюуны эрэлт хэрэгцээг чанартай уран бүтээл, ажил үйлчилгээгээр хангаж, ардын уламжлалт урлагийн орчин үеийн болон дэлхийн сонгодог урлагтай хослуулан хөгжүүлж, төрөөс баримтлах соёлын бодлогыг хэрэгжүүлэхэд оршино” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд байгууллагын дотоод хяналтын баг төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хийсэн байна. Хяналт шалгалтаар зөрчилтэй асуудал илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 682.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20.8 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан бөгөөд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Авлага	0	0.4	0.4	
Бараа материал	221.7	228.8	7.1	3.2
Үндсэн хөрөнгө	440.5	412.2	-28.3	-6.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>662.2</b>	<b>641.4</b>	<b>-20.8</b>	<b>-3.1</b>
<b>Өр төлбөр</b>	<b>0</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	662.2	641.0	-21.2	-3.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>662.2</b>	<b>641.4</b>	<b>-20.8</b>	<b>-3.1</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага, өглөгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 0.4 сая төгрөг болсон байна.

Авлага, өглөгийн данс нь 0.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Татварын хэлтэст ХАОАТ-ын илүү суутгаж шилжүүлсэнтэй холбоотой байна.

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 3.2 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 221.7 сая төгрөгийн эхний ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 42.3 төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 5.4 сая төгрөг нийт 47.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 40.6 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 228.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 6.3 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 440.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан /хөгжим хэрэгсэл, эвхэгддэг тайз/ 28.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 57.2 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 412.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Засгийн газрын хувь оролцоо 3.1 хувиар буурсан байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 641.0 сая төгрөг байгаа нь тайлант хугацааны үр дүн 21.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая.төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	666.0	682.5	16.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12.7		-12.7
Нэмэлт санхүүжилтийн орлого	8.5	15.5	7.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	185.7	34.2	-151.5
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>872.9</b>	<b>732.2</b>	<b>-140.7</b>
Цалин, шимтгэлийн зардал	481.6	465.4	-16.2
Бусад бараа үйлчилгээний зардал	166.7	190.3	23.6
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27.7	40.5	12.8
Бараа үйлчилгээний бусад зардал	42.2	57.2	15.0
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>718.2</b>	<b>753.4</b>	<b>35.2</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>154.7</b>	<b>-21.2</b>	<b>-175.9</b>

Хөгжимт драмын театрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 16.5 сая төгрөг буюу 2.4 хувиар өссөн нь ашиглалтын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,754.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 1,072.4 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 682.5 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 682.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 682.5 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 661.0 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 21.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жил нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 11.5 сая төгрөгийн санхүүжилт авч Засаг даргын А/765 дугаар захирамжаар “Улаан орхимжны давалгаа” жүжгийн хувцас хэрэглэлд зарцуулсан байна. Мөн нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын өөрийн орлогын хүрээнд бий болсон 4.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 7 ажилтанд 4.1 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд тус байгууллага нь “Улаан орхимжны давалгаа” эмгэнэлт жүжгийг тоглосонтой холбоотойгоор хувцас, жижиг хэрэгсэл буюу бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 7.1 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 91.3 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд нийт 682.5 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 661.0 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 96.9 хувь байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулжээ. Үүнд:

- Албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд 15.1 сая төгрөг, албан томилолтын зардалд 1.8 сая төгрөг, бусад тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Суудлын автомашин ашиглалтын хувьд: Hyundai county маркийн 2012 онд үйлдвэрлэсэн 81.8 сая төгрөгийн анхны өртөг бүхий автомашинтай бөгөөд шатахуун зардалд 0.9 сая төгрөг, Hyundai super aego маркийн 2011 онд үйлдвэрлэсэн 14.2 сая төгрөгийн анхны өртөг бүхий автомашинд тайлант онд шатахууны зардал гараагүй байна. Пургон маркийн 2020 онд үйлдвэрлэсэн 33.6 сая төгрөгийн анхны өртөг бүхий автомашинтай бөгөөд шатахууны зардалд 1.8 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 6.5 сая төгрөгийг олгожээ.
- Бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 21.5 сая төгрөгийг хэмнэсэн нь нийт батлагдсан төсвийн 18.9 хувьтай тэнцүү байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах гэж заасантай нийцэж байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар зарим арга хэмжээний тухай” засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн Хөгжимт драмын театр нь 2021 онд нийт 69.6 сая төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь ил тод мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 18.9 хувь буюу 21.5 сая төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар уран бүтээлийн зардлын гүйцэтгэлд залилантай холбоотой асуудал үүссэн эсэх, дараа онд халаалтын зардлын зарцуулалтыг анхааран авч үзнэ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 13.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 11.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэн, 1.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй 3 алдаа, зөрчлийн дүн 13.4 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 6.8 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

#### **4.1 Албан шаардлага**

Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас ажилчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт олгохдоо 2453200 төгрөгийн НДШ-ийг суутгасан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Татварын хэлтэст 433278 төгрөгийн ХАОАТ-ыг илүү шилжүүлж, авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.4.8.Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас тухайн байгууллагын төсөв захирагч нь өөрийн хамаарал бүхий этгээдтэй гэрээ байгуулж 8750000 төгрөгийг жүжгийн хөгжмийн найруулга, мөн фонаграмм хийлгэсний хөлсөнд олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.4 дэхь “Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх”, 7.2.5 дахь “Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх”, 8.1 “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана”, 8.2 “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй”, Төсвийн тухай хуулийн 6.4.1.Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4.2 Зөвлөмж

**1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Албан томилолтын зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад 1.8 сая төгрөгийн албан томилолтын зардал гарсны удирдамж, ажлын тайлан, илтгэх хуудас байхгүй, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Албан томилолтын зардлыг олгохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

-----oOo-----

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс					
				Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөгжимт драмын театр	4	13.4			3	11.6	1	1.8